



“ХҮН БОЛОХ БАГААСАА” ТӨСЛИЙН ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ерөнхий мэдээлэл:

“Хүн болох багаасаа” хүүхдийн спорт, гадаад хэл, авьяас сургалтын төсөл нь Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/17, 13/18, 13/19 дүгээр тогтоолоор батлагдсан.

“Хүн болох багаасаа” хүүхдийн спорт, гадаад хэл, авьяас сургалтын төслийн зорилго нь Дорнод аймгийн хүүхдүүдийн спорт, урлагийн авьяас чадварыг нээн хөгжүүлж, гадаад хэлний мэдлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн, багаар ажиллах чадвартай, зөв хүмүүжилтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх.

Хамрах хүрээ:	Хувь хүний хөгжлийн сургалтад “Хүн болох багаасаа” хүүхдийн спорт, гадаад хэл, авьяас сургалтын төсөлд хамрагдсан нийт 7602 хүүхдийг хамруулна. Хуулийн этгээд нь дараах багцуудаас сонгон тендерт оролцоно. 1. Спортын сургалтын төсөлд хамрагдах 14 сумын нийт 2500 хүүхэд 2. Гадаад хэлний сургалтын төсөлд хамрагдах 14 сумын нийт 2278 хүүхэд 3. Авьяас сургалтын төсөлд хамрагдах 14 сумын нийт 2824 хүүхэд
Сургалт зохион байгуулах хугацаа:	Сургалт хоёр хичээлийн жил дамжин үргэлжлэх бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилийн III улирлаас 2024-2025 оны хичээлийн жилийн II улирал дуустал үргэлжилнэ.
Сургалтын нэр төрөл, агуулга	Хувь хүний хөгжлийн сургалтанд 1 хүүхэд нэг сард 4 цаг буюу төсөл хэрэгжих 6 сарын хугацаанд нийт 24 цагийн сургалтанд хамрагдсан байна. Хувь хүний хөгжлийн сургалтын хөтөлбөр нь дараах сэдвүүдийг бүрэн хамруулсан байна. Үүнд: 1. Үндэсний бахархал 2. Сэтгэл зүйн боловсрол 3. Хүмүүнлэг, Сайн дурын ажил 4. Санхүүгийн боловсрол
Захиалагч нь:	1. Сургалт зохион байгуулах байрны зохих дэмжлэг үзүүлнэ. 2. Сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнд захиалагчийн хяналт тавина.

Сургалт зохион байгуулах ерөнхий шаардлага:


1.	Сургалтад “Хүн болох багаасаа” хүүхдийн спорт, гадаад хэл, авьяас сургалтын төсөлд хамрагдсан хүүхдүүдийг тэгш хүртээмжтэй хамруулна.
2.	Сургалтыг хүүхдүүдийн нас, сэтгэхүй, мэдлэгийн түвшинд нь тохирсон олон хувилбарт хөтөлбөрөөр чанартай зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрийг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраар батлуулна.
3.	“Хүн болох багаасаа” төслийн спорт, гадаад хэл, авьяас сургалтыг гүйцэтгэхээр захиалагчтай гэрээ байгуулсан талуудтай хамтран ажиллана.
4.	Төсөл хэрэгжих хугацаанд нэг хүүхдийг нийт 24 цагийн сургалтад хамруулсан байна.
5.	Хүүхдийг хувь хүний хөгжлийн зохих түвшний мэдлэг боловсролтой, багаар ажиллах чадвартай, зөв хүмүүжилтэй, эх оронч үзэлтэй, түүх соёлоос суралцсан иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын олон хувилбарт бүтээлч аргуудыг ашиглан зохион байгуулна.

6.	Бусад ижил төрлийн дугуйлан, клуб, сургалтын төв, сургуулиудтай хамтарсан нөхөрсөг уулзалт, хэлэлцүүлэг, олон нийтийн хүмүүнлэгийн ажил, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хүүхдүүдийг идэвхтэй оролцуулна.
7.	Сургалтын санхүүжилтийг сургалтад хамруулсан хүүхдийн тоо, сургалтын цагийн сар тутмын гүйцэтгэлийг тооцож олгоно. Иймд тендэрт оролцогч нь сургалтад хамруулах хүүхдийн тоог багцад заасны дагуу тооцож, төсвийн задаргааг дэлгэрэнгүй боловсруулна. /нэг хүүхдийн 1 цагийн сургалтын хувьсах зардал 1,500 төгрөг/
8.	Суралцагч хүүхдүүдийн амжилтын түүхийг эцэг, эх, асран хамгаалагч, ангийн багш, сургуульд нь хуваалцаж, байнгын эргэх холбоотой хамтран ажиллана.
9.	Сургалтын үйл ажиллагаа, хүүхдүүдийн хандлага төлөвшлийн ахиц амжилтын түүхийг олон нийт, хэвлэл, мэдээлэл, цахим хуудсаар тогтмол мэдээлж, тайлагнана.

Сургалтын тендэрт оролцогчдод тавигдах шаардлага:


1.	Тендэрт оролцох албан хүсэлт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2.	Байгууллагын танилцуулга: Үйл ажиллагааны чиглэл
3.	Хүний нөөцийн мэдээлэл: <ul style="list-style-type: none"> - Хувь хүний хөгжлийн сургалтыг гүйцэтгэх хуулийн этгээд нь 4 төрөл / Сайн дурын ажил, Санхүүгийн боловсрол, Харилцааны ур чадвар, Сэтгэл зүйн боловсрол / тус бүрийг заах туршлага, ур чадвартай, бакалавр болон түүнээс дээш боловсролтой, эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон тухайн чиглэлээр сургалт зохион байгуулах Сургагч багшийн эрхтэйг нь баталгаажуулсан сертификат, үнэмлэхтэй 4-өөс доошгүй сургагч багштай байна. - Сургалт зохион байгуулах хүний нөөц /Сургагч багш бүрийн дэлгэрэнгүй танилцуулга
4.	Ажлын туршлага: Сургагч багш нарын сургалт зохион байгуулж байсан туршлага, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний амжилтын түүх, хамтран ажилласан байгууллагын мэдээлэл
5.	Сургалт явуулах орчин, нөхцөл: Сургалтын хөтөлбөр, сургалт явуулах анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл
6.	Давуу тал: <ul style="list-style-type: none"> - Олон улсын байгууллагын Сургагч багшийн эрхтэй багштай бол давуу тал болно. - Тендэрт оролцогч нь олон улсын байгууллага, ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа төсөл, хөтөлбөртэй хамтран ажилласан бол давуу тал болно. /Хамтран ажилласан болон ажиллаж байгаа гэрээний хуулбар/
7.	Сургалтын төсөв: "Хүн болох багаасаа" хүүхдийн сургалтын төсөл нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжинэ. <ul style="list-style-type: none"> - Төслийн санхүүжилтийг: Сургалт явуулах анги танхимын урсгал зардал, сургалтын хэрэглэгдэхүүн, багшийн урамшуулал, багшийн сумдад ажиллах унааны зардалд төлөвлөх - Санхүүжилтийг төслийн сургалтад хамруулах хүүхдийн тоо, сургалтын цагийн сар тутмын гүйцэтгэлээр тооцож олгоно. - Бусад эх үүсвэр Зөвшөөрөгдөхгүй зардал: Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцоогүй хүнд цалин урамшуулал олгох, тавилга тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас худалдан авах

Хянасан: Аймгийн Засаг даргын тамгын газрын
Нийгмийн Бодлогын хэлтсийн дарга


Э.Эрдэнэбилэг

Боловсруулсан:

Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга


Б.Чимэддорж

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга


Ч.Ариунаа

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга


Э.Жавхлан